Covid 19 Ажлын хэсгийн уулзалт-I

Хаана: 6 давхрын хурлын заал, НҮБ-ийн төв байр, УБ, Монгол

Өдөр: 2020 оны 6 сарын 30, 09-00:14:00

	Ажлын хэсгийн гишүүд	Гишүүн бус
Оролцсон	1.Ц.Эрдэнэбат, Ерөнхийлөгчийн Зөвлөх (Zoom-р оролцсон) 2. А.Мөнхболд, Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Үндэсний Хөгжлийн Газар 3. В.Болормаа, Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын мэргэжилтэн, ХХААХҮЯ	1. В.Шинэнэмэх, Платформын Менежер, МТНП, НҮБХХ 2. Д. Баярмаа, Санхүү ба админ хариуцсан мэргэжилтэн, МТНП, НҮБХХ 3. Н.Цолмон, Платформын Ажилтан, МТНП, НҮБХХ
	4. Ц.Будням, Профессор, МУ-ын Эрдмийн Их Сургууль	
	5. Б.Батхишиг, Монгол дахь салбарын захирал, SFA 6. А.Хандармаа, Харилцаа, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн, AVSF 7. Ж.Чанцаллхам, Төслийн менежер, WCS 8. Э.Нандин-эрдэнэ, Төсөл, хамтын ажиллагаа хариуцсан менежер, TOC 9. А.Энх-амгалан, Захирал, Бодлого Судлалын Төв 10. Л.Ням-очир, Зөвлөх, TNC 11. Г.Намуулан, Сургалтын менежер, МБАНХ 12. Ж.Эрдэнэсувд, Гадаад харилцаа хариуцсан мэргэжилтэн, МННХ	
	13. Р.Саруулсайхан, Менежер, Мөнхбумууд ХХК 14. Г.Эрхэмболд, Менежер, Snowfields ХХК 15. Б.Батзолбоо, Үйл ажиллагааны менежер, Дарханы АШЦогцолбор 16. Б.Балжинням, Бизнес хөгжил, төлөвлөлт хариуцсан менежер, Баялаг Өлзий ХХК	
Оролцоогүй	1. Б.Бадруун, Олон улсын харилцаа, төсөл хариуцсан дарга, ХХААХҮЯ 2. Б.Батбаатар, Ногоон хөгжил, санхүүжилт хариуцсан мэргэжилтэн, БОАЖЯ 3. Э.Батбаяр, Захирал, ХАА-г дэмжих сан 4. Ц.Батсүх, Профессор, СЭЗИС 5. Ч.Хаббард, SFA 6. Н.Рой, Төслийн координатор, Pur төсөл 7. А.Госай, Өмнөд Азийг хариуцсан менежер, Textile Exchange	

1. **Covid 19 ажлын хэсгийн анхны уулзалтаас гарах үр дүн:**

- "Ковид 19-ийн улмаас Монголын ноолуурын салбарт тогтвортой, ногоон хөгжил, хамтын ажиллагааг чухалчлах шаардлага" сэдэвт танилцуулга презентаци
- Ковид-ын салбарт үзүүлж буй нөлөө, салбарыг хэрхэн тогтвортойгоор сэргээх гарц, шийдүүдийн талаар хэлэлцэх

ХӨТӨЛБӨР

	Цаг	Үйл ажиллагаа	Илтгэгч/модератор
1.	09:00	Бүртгэл, кофе	
2.	09:30	Нээлт Ковид-19 ажлын хэсгийн зорилгыг танилцуулах	Нашида Саттар, Монгол дахь НҮБХХ-ийн Суурин төлөөлөгчийн орлогч
3.	09:40	Танилцуулга презентаци: Ковид 19-ийн улмаас тогтвортой байдал, ногоон хөгжил, хамтын ажиллагаанд төвлөрөх шаардлага	В.Шинэнэмэх НҮБХХ-ийн МТНП-ийн менежер
4.	10:00	Хэлэлцүүлэг 1. Та энэхүү ажлын хэсгээс ямар хүлээлттэй байна вэ? Яагаад энэ ажлын хэсэгт орж ажиллах шийдвэр гаргасан бэ?	Мэдэгдэнэ
5.	11:00	Хэлэлцүүлэг 2. Ковид 19-ийн нөлөөгөөр салбарын болон танай байгууллагын бизнес загвар хэрхэн өөрчлөгдсөн бэ?	Мэдэгдэнэ
6.	12:00	Хэлэлцүүлэг 3. Ковид 19-той холбоотой үүссэн сорилтуудыг даван гарахын тулд Монгол Улсын Засгийн Газар болон ОУБ-ууд, хувийн хэвшил, бусад оролцогч талууд ямар арга хэмжээ авах хэрэгтэй гэж та бодож байна?	Нашида Саттар, ОСТ Х.Хишигжаргал Монгол дахь НҮБХХ-ийн хөтөлбөрийн шинжээч
7.	13:00	Дүгнэлт, дараагийн алхмууд	Нашида Саттар, НҮБХХ-ийн Суурин төлөөлөгчийн орлогч В.Шинэнэмэх, МТНП-ийн менежер
8.	13:30 – 14:00	Үдийн зоог	

Уулзалтын товч тэмдэглэл

Нашида Саттар, Монгол дахь НҮБХХ-ийн Суурин төлөөлөгчийн орлогч

Дэлхий дахинд "*Ковид*-19" халдварт *цар* тахалтай холбоотойгоор онцгой нөхцөл байдал үүсээд байгаа бөгөөд Монголын хувьд ч ялгаагүй эдийн засагт нөлөөтэй гол салбарууд өртөөд байна. Цар тахлын нөлөө нэмүү өртгийн сүлжээг бүхэлд нь хамарч иргэдийн, тэр дундаа нийгмийн эмзэг бүлэг, орлого багатай иргэдийн амьдралд хүндээр тусаж байна. Монголын эдийн засагт чухал байр суурь эзэлдэг ноолуурын салбар ч хүнд байдалд ороод байгаа бөгөөд дэлхийн ноолуурын салбар мөн адил бэрхшээлийг амсаж байна. Нөхцөл байдал ийм байгаа ч бидэнд олж харж, ашиглаж чадвал тодорхой боломжууд бас нээгдээд байна. Хүн төрөлхтөн энэхүү цар тахлаас үүдэн тогтвортой байдал, ногоон ирээдүй, шударга тэгш оролцоот байдал хичнээн чухал болохыг урьд урьдахаас илүү ойлгож эхэлж байна. Энэхүү өөрчлөлтийг авчрахын тулд ноолуурын салбарынхан нэгдэн нийлж, тулгараад байгаа сорилтуудыг ярилцаж, шийдлүүдээ тодорхойлох нь маш чухал. Хамтын хүчээр энэхүү сорилтуудыг даван туулж, нэгдэн нийлэхээр Платформын үйл ажиллагаанд оролцож буй та бүхэнд амжилт хүсье!

Хэлэлцүүлэг 1. Та энэхүү ажлын хэсгээс ямар хүлээлттэй байна вэ? Яагаад энэ ажлын хэсэгт орж ажиллах шийдвэр гаргасан бэ?

Монгол Улсын Эрдмийн Их Сургууль, Ц.Будням: Хөгжлийн Төлөөх Эрдэмтэд ТББ-ийн захиалгаар "Корона вирусын тархалт ба дэлхий эдийн засгийн нөлөөлөл" гэдэг сэдвээр судалгааны ажил гүйцэтгэж ном гарсан. Бид Хятадын эдийн засгийн агшилт ба Монголын эдийн засагт энэхүү агшилтын үзүүлэх нөлөөг судалсан. Манай ноолуурын салбарын хувьд кластерийг зөв гаргаж ирэх хэрэгтэй. Бид арга зүйн талаас нь зөвлөж болно, нэгдсэн төлөвлөгөө гаргах ажил дээр өөрийн шавь Батсүхийн хамт хамтран ажиллах боломжтой. Бид бас "21-р зуун" гэж ном бичсэн байгаа (номнуудаа гардуулав).

Баялаг Өлзий ХХК, Б.Балжинням: Бид ижил зорилго, ижил сорилтуудтай нүүр тулаад байгаа учраас хамтран ярилцах, шийдэл олох, үйлдвэрлэгчийг төлөөлөн дуу хоолойгоо хүргэх, санал солилцох, бусдаасаа суралцах зорилготой ирсэн. Мөн бизнест маань тулгараад байгаа асуудлыг шийдвэрлэж болох санал, санаачлага, гарц, зөвлөмж сонсох байх гэдэг хүлээлттэй байна.

МБАХолбоо, Г.Намуулан: Манай холбоо 18 аймагт салбартай, малчдыг төлөөлсөн байгууллага учраас Ковид-ын цаг үе дэхь малчдын дуу хоолойг илэрхийлэх зорилготойгоор ажлын хэсэгт нэгдсэн. Цөөн малтай малчдад нилээн хүнд тусаж байгаа гэсэн судалгаа гараад байна. Санхүүгийн дэмжлэг авах хүсэлтэй малчдын дийлэнх нь цөөн малтай малчид байна. Платформ нэгэнт ноолуурын салбарын малчнаас эхлээд үйлдвэрлэгчид хүртэл өргөн хүрээг хамарч байгаа болохоор платформын дор хамтарсан гишүүдын шийдвэрийг бодлого тодорхойлох түвшний хүмүүст хүргэх байх гэдэг хүлээлттэй байна.

МННХ, Ж.Эрдэнэсувд: Ковид-19 манай салбарт их хүчтэй нөлөөлж байна. Экспортын гэрээнүүд цуцлагдсан, үйлдвэрүүдийн борлуулалт зогссон. Ажлын байраа хадгалж үлдэхийн тулд яах вэ

гэдэг асуудалтай тулгараад байгаа. Та бүхний мэдэж байгаачлан манай салбарын үйлдвэрүүдийн ажилчдын 80% нь эмэгтэйчүүд байдаг. Тийм учраас энэхүү ажлын хэсгээс үр дүнтэй, цаг үеийн нөхцөл байдлыг тусгасан шийдвэрүүд гаргаж ажиллах байх гэж найдаж байгаа.

Дарханы АШБоловсруулах Цогцолбор, Б.Батзолбоо: Бидний зүгээс платформ-той ноос, ноолуурын хүрээнд түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоог бий болгох, боловсруулахад түлхүү хамтран ажиллах юм байна.

Бодлого Судлалын Хүрээлэн, А.Энх-амгалан: Сүүлийн 20 жил тогтвортой МАА чиглэлээр ажиллаж байна. Бид чадавхи бэхжүүлэх хүрээнд, бүтэц зохион байгуулалт (Institutional), санхүүжилтийн хүрээнд яаж шийдэх вэ гэдэг загвар боловсруулаад туршиж үзээд нааштай үр дүнгүүд гарчихсан байгаа. Ногоон санхүүжилт хэрэглэсэн, бэлчээрт хамгийн сөрөг нөлөө үзүүлж байгаа малын тоог бууруулсан, ноолуурын гарцыг сайжруулах чиглэлээр малчдад сургалт явуулж, чанартай ноолуур бэлтгүүлээд илүү үнээр үйлдвэрүүдэд зарж боловсруулах загвар боловсруулчихсан байгаа. Яг одоо загвараа дэлгэрүүлэх гэхээр төр засгийн дэмжлэг, ОУБ-дын оролцоо дутаад байна. Зөв бодлогоор эдийн засгийн хөшүүрэг гаргаад ирвэл малчид ямааны тоо толгой биш чанарт нь анхааралаад ирнэ. Энэ ажлын хэсэгт орж ирсэн миний зорилго бол Донорууд бид нэгдэж байж Төр засагт шахалт өгөхгүй бол энэ алдаатай бодлого ноолуурын салбарыг тогтвортой биш харин тогтворгүй болгоод байна. Үүнийг өөрчлөхийн төлөө нэгдье гэсэн зорилго байна.

ХХААХҮЯам, В.Болормаа: 10-аад жилийн өмнө тогтвортой ноолуур, хариуцлага, бэлчээрийн асуудлыг ярьдаггүй байсан бол сүүлийн үед бэлчээрээ хамгаалах, эрүүл мал, чанартай ноолуур, тогтвортой байдал гэх зүйлийг ярьдаг болсон нь ОУБайгууллагуудын хэрэгжүүлж ирсэн болон одоо хэрэгжүүлж буй төслүүдийн үр дүн гэж ойлгодог. Ийм платформ байгуулах нь их оновчтой шийдэл. Чанарт суурилсан үнийн систем рүү орох нь хамгийн чухал байна. Зөвлөл сайн ажиллаж, эдийн засгийн хөшүүргийг нь ашиглан малчид, үйлдвэрлэгчид, бизнесийнхэн хамтран ажиллаж үр дүнд хүрэх боломжтой. Ноолуурын борлуулалт гадны худалдаачдаас 80-90% хамааралтай байгаа байдлыг өөрчлөхийн тулд эрх зүйн орчныг өөрчлөх хэрэгтэй. Ялангуяа экспортлогчид зөвшөөрөл авдаг болох, квот-той болох, жишиг үнийг баримталдаг байх, платформын үнийг баримтлах ч гэхчилэн зохицуулалтуудыг хийх боломжтой. Мөн ноос ноолуурын салбарт үйл ажиллагаа явуулж байгаа бизнесүүд зөвшөөрөлгүй явж байгаа. Ялангуяа анхан шатны үйлдвэрүүдийг зөвшөөрөлтөй болгоё, зөвшөөрлийн хууль руу оруулья гэдэг чиглэл байгаа. Платформ энэ мэт талууд дээр түшиг тулгуур болоод, тооцоо судалгааг үндэслэлтэй гаргаж өгөөд, тэрийгээ асуудал дэвшүүлж гаргаж тавиад байвал болохгүй юм байхгүй гэж бодож байна.

WCS, Ж.Чанцаллхам: WCS малчидтай хамтран ажиллаад нилээн хэдэн жил болж байгаа учраас энэ туршлагаа хуваалцья, нөгөө талаар ижил төстөй үйл ажиллагаа явуулж байгаа бусад газруудаас бас туршлага судлая гэдэг зорилготой ирсэн. Төслүүд зогссон ч үйл ажиллагаа нь тогтвортой үргэлжилдэг систем бий болгохын төлөө бид нар нэгдэж дуу хоолой болох хэрэгтэй. Дараагийн асуудал нь чанартай ноолуур бэлтгэх нэг эх үүсвэр нь чанартай бэлчээр гэдэг асуудал орхигдоод байдаг. Төр засгаас барьж байгаа бодлого дутаад, мухардалд ороод байна. Нарийн ноолуур дээр үнэлгээ өсгөөд квот тогтоох тухай ярьж байгаа ч бэлчээрийг зөв зохистой ашигласан учраас гэх

үнэлгээ орчихсон стандарт, журмыг бий болгохгүй бол ноолуурын чанар дээрээ анхаарч байтал бэлчээрийн асуудал бүр хүндрэх тал үүсэх вий.

SFA, Б.Батхишиг: МТНЭвслийн зүгээс Ковид-той холбоотой хэд хэдэн ажил хийх, хувь нэмрээ оруулах санал, шийдлүүдийг дэвшүүлж байгаа. Эвсэлд бүртгэлтэй байгууллагууд маань хаалгаа бариад, машинаа зогсоочихсон байна. Манай ноолуурын худалдаа гадаад зах зээлээс хэт хамааралтай байгаа ч гадаад зах зээлийнхээ хэрэгцээ, шаардлагыг тооцож үздэггүйгээс болоод олон төсөл, хөтөлбөрүүд амжилттай хэрэгжсэн ч гэсэн урт хугацаанд үзүүлэх нөлөө багатай байна. Манай байгууллага Ковид-той холбоотой стратеги төлөвлөгөө гаргасан. 100 гаруй брэндүүд нэгдээд Ковид-ийн дараах ноос, ноолуурын салбар дэлхий дахинд ямар түвшинд хүрэх, цар тахалтай холбоотойгоор бизнесийн чиглэл, бизнес төлөвлөгөөнд ямар стратеги өөрчлөлт гарах вэ гэдэг ерөнхий дүр зураг гарчихсан байгаа. Монгол болон Өвөр Монголд Ковид-той холбоотойгоор хэд хэдэн чиглэлд хамтарч ажиллах, энэ чиглэлд хүчээ нэмэх, зах зээлийг түлхүү оролцуулах сонирхолтой байгаа. Хоршоод, бэлтгэлийн байгууллагуудын уялдаа холбоо, итгэлцлийг бий болгож чадах юм бол дараа жилийн бэлтгэлийг чанарт суурилсан, ангилан ялгасан байдлаар хийж, зах зээлийн шаардлагыг хангах боломжтой. Энэ асуудал дээр гадны зах зээлийн эрэлт хүсэлт ямар байгааг хэлэх, хамтран ажиллах боломжтой. Худалдан авагч өнөөдөр чанарыг мэдэжж чухалчилна. Хоёрт нь, үйл ажиллагаа явуулж байгаа чанарын менежментэд их анхаарч байна. Өөрөөр хэлбэл, гүйцэтгэлд суурилсан урамшуулал, гүйцэтгэлд суурилсан татаасын асуудлыг тавьж байгаа. Энэ үзүүлэлтүүдээ баталж чадвал тухайн байгууллагын ноолуурыг илүү үнээр авах боломж байгаа. Одоо үүсээд байгаа нөхцөл байдал гэвэл түүхий болон самнасан ноолуурын илүүдэл, бэлэн бүтээгдэхүүний илүүдэл үүссэн дүр зураг гадаад дотоодгүй адилхан байна. Тийм болохоор түүхий эд таталт нэгдүгээр асуудал биш харин хариуцлагатай эх үүсвэр хамгийн чухал үзүүлэлт болно.

TNC, Л.Ням-очир: Манай байгууллага байгаль хамгааллын чиглэлээр 4 аймаг, 7 суманд малчидтай хамтран ажилладаг. Ноолуурын үнэ унаснаар Ковид малчдын амьжиргаанд шууд нөлөөлж байна. Ноолуурын үнийг өсгөх бодлого баймаар байна. Энэ жил яалт ч үгүй манай дотоодын үйлдвэрлэгчид маш их ноолууртай боллоо. Тэгэхээр гадаад зах зээлийг оруулж ирмээр байна. Ялангуяа Өвөр Монгол, Хятадаас ноолуур худалдан авах ажиллагааг зохион байгуулалттай оруулж ирж өрсөлдөөн бий болгохгүй бол болохгүй байна. Тэртэй тэргүй бид нар 20,30 жил Хятадаас хамааралтай амьдарч ирсэн. Тэгэхээр Хятадын чэнж-үүдийг оруулж ирэх нь зүйтэй л гэж бодож байна. Ямар бодлогоор оруулж ирэхээ бодох л хэрэгтэй.

Мөнхбумууд Кашмир, Р.Саруулсайхан: Ковид-той холбоотойгоор борлуулалт 60-70% буурчихсан, үйлдвэр 20-30% үйл ажиллагаатай, ажлын байраа яаж хадгалж үлдэх вэ гэдэг байдалтай байна. Энэ ажлын хэсэгт яагаад орж ирсэн бэ гэхээр бусад ААН-үүд яаж зохицуулж байна, дахиад ийм гэнэтийн нөхцөл байдал үүсвэл яаж тэсэж үлдэх вэ гэдэг санал, туршлагаа солилцох гэж ирсэн.

AVSF, А.Хандармаа: Ковид мэдээж гэнэтийн, таашгүй нөхцөл байдалд оруулаа. Ковид бүхэл бүтэн сүлжээнд нөлөөлөөд эхэллээ. Тэгэхээр энэ платформоос юу хүлээж байна гэхээр нэгдсэн дуу хоолой, дүгнэлт, зөвлөмж гаргаад төр засгийн түвшинд гаргаж тавих, цар тахлын үед ийм арга барилаар, нэмүү өртгийн сүлжээнд бид ингэж ажиллавал энэ нөхцөл байдлыг даван туулах боломжтой гэдэг тодорхой зөвлөмжүүд ажлын хэсгээс гарах байх гэж найдаж байгаа. Манай байгууллагын хувьд малчидтай 5жилийн турш хамтран ажиллаад зохих ёсоор ноолуур бэлтгүүлээд үйлдвэрүүдтэй холбож өгөөд гадаад зах зээл рүү холбож өгсөн сайн туршага, загвар бэлэн байгаа. Орон нутгийн хэмжээнд ноолуурын чанарыг шалгаад, үнэлээд, баталгаажуулчихдаг системтэй, өөрсдийн гэсэн гэрчилгээтэй, хороотой загварыг бий болгосон. Энэ загвараа санал болгоход бэлэн байна. Мөн дээрээс нь үйлдвэрүүдтэй хамтран ажиллаж тогтвортой байдлын ач холбогдлыг

таниулж хэрэгжүүлэх чиглэлд бас ажилладаг. Малчдын түвшинд ч үйлдвэрүүдийн түвшинд сэтгэлгээний өөрчлөлт оруулах чиглэлүүдээр хамтран ажиллах боломжтой.

ТОС, Э.Нандин-эрдэнэ: 2013 он хүртэл банкууд тухайн бизнес байгаль орчин, нийгэмд ээлтэй эсэхийг харгалзаж зээл олгодоггүй байсан бол ТОС буюу тогтвортой санхүүгийн зарчмууд гарч ирснээс хойш энэ асуудлуудыг үнэлж байж зээл олгогддог болсон. Манайх банкуудын гишүүнчлэлтэй. Тийм болохоор банк санхүүгийн салбарыг төлөөлөөд орж ирж байна гэж ойлгож байгаа. Ноолуурын хувьд салбарт нь барих бодлого, энэ салбарын байгаль орчны үнэлгээн дээр чек лист гаргасан. Одоогоор тогтвортой ноолуурын зээлийн шалгуурыг боловсруулж байгаа. Ковид-той холбоотойгоор ноолуурын салбар банкны хувьд илүү сонирхолтой болж ирж байна. Тэгэхээр зээлийн, хөрөнгө оруулалтын шаардлага дээр баримтлах чиг баримжаагаа энэ ажлын хэсгээс авах хүлээлттэй байна.

Хэлэлцүүлэг 2. Ковид 19-ийн нөлөөгөөр салбарын болон танай байгууллагын бизнес загвар хэрхэн өөрчлөгдсөн бэ?

МЭИС, Ц.Будням: Манай улсын хувьд банкны систем сул хөгжсөн, хариуцлага муутай явж ирсэн. Мөнгөний хүү их байна гэж байна. Хүүг бууруулахдаа биш хадгаламжийн хэмжээг багасгах чиглэлд ухаалаг бодлого барих хэрэгтэй. Ийм суурь өөрчлөлтүүдийг хийвэл ноос, ноолуурын салбарт ч эерэг нөлөө мэдрэгдэнэ. Манайд салбар хоорондын уялдаа байдаггүй. Тиймээс энэ чиглэлд судалгаа хийж үр дүнг нь ном болгон хэвлүүлсэн.

ХХААХҮЯам, В.Болормаа: Түүхий эд бэлтгэн нийлүүлэлт, Хаан ширхэгт дээр ч юм уу стандарт байгаад байгаа ч мал аж ахуйн чиглэлд үйл ажиллагааны мөрдөх стандарт алга. Тиймээс "Хариуцлагатай нүүдэлчин" гэдэг стандарт бий болгох санаачлага Ногоон Алт төслөөс гарсныг Яам дэмжсэн. Ажлын хэсэг 5 хэсэгт хуваагдан ажиллана. Үржил селекц, бэлчээр ашиглалт, малын арчилгаа тэжээл, вакцин туулга, малын түүхий эд бэлтгэлийн хүрээнд үйл ажиллагааны стандартууд гарна. МТНП-ийг ийшээгээ хүчээ нэгтгэхийг хүсэж байна.

SFA, Б.Батхишиг: Ковид-оос үүссэн нөхцөл байдлыг харахад тогтвортой чиглэл рүү яаралтай орох цочрол өгч, хурдавчлах шаардлага үүсгэлээ. Хятад худалдаачдын нөлөөгөөр Монгол улс ноолуурын хар зах зээлийн бэлтгэн нийлүүлэлтийг сүүлийн 20 хэдэн жил хийгээд явчихсан. Үндэс суурь нь хүчтэй тэлсэн ийм системийг өөрчлөхийн төлөө Монголд ч олон улсын түвшинд ч их ажил хийгдсэн. Монголын хувьд бодлогын түвшинд хангалттай олон шийдвэрүүд гарсан, механизм нь байгаа ч ажиллахгүй байна гэж боддог. Бид МАА-г зохистой эрхлэх, бэлчээрийг зохистой ашиглах, нийгэм байгаль орчинд ээлтэй байх, бэлэн бүтээгдэхүүний тэмдэгтийн баталгаажуулалт гэсэн үндсэн 4 түвшний 116 шалгуур үзүүлэлт гаргаж ирж загвар төсөл боловсруулаад туршиж үзсэн. Энэ төслийн хүрээнд 80 тонн ноолуур худалдан авч боловсруулласан. Нилээн сайн туршлага хуримтлуулсан. Хуваалцахад бэлэн байна. Харин Платформын зүгээс хамтын зөвшилцөлд хүрэх үр дүнг хүлээж байгаа.

Үндэсний Хөгжлийн Газар, Хөгжлийн Бодлого Төлөвлөлтийн Газар, А.Мөнхболд: Ноолууртай холбоотой олон судалгаа байна. Ноолуур бол эдийн засагт чухал нөлөөтэй салбар. Төр хувийн хэвшлийн уялдаа холбоог сайжруулах шаардлагатай. Монгол улс ноолуурын том бэлтгэгч боловч нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэл маш сул хөгжиж ирсэн. Бидэнд судалгаа хангалттай бий. Одоо ажил болгох хэрэгтэй. Системийн динамик загвар гаргасан. Ноолуур нь малчдын гол орлого боловч нөгөө талаасаа байгаль орчинд үзүүлэх нөлөө ихтэй. Ноолуурын гүн боловсруулалтын салбарт өндөр технологи орж ирээгүй байна. Төрөөс энэ тал дээр дэмжлэг хэрэгтэй. Ковид-ийг давуу тал, боломж гэж харах, ажиллах хэрэгтэй.

МННХ, Ж.Эрдэнэсувд: Үйлдвэрүүд хүнд байдалтай байна. 40-70%-ийн сул зогсолттой, борлуулалт байхгүй, ажлын байраа л хадгалж үлдэхийн төлөө ажиллаж байна. Ийм нөхцөл байдлуудтай уялдан Холбооноос төрөл бүрийн сургалтуудыг зохион байгуулж байгаа. Санхүүгээ энэ цаг үед яаж төлөвлөх, бизнес моделио яаж өөрчлөх, ногоон зээлийг хэрхэн авах гэх зэрэг асуудлуудаар зөвлөгөө өгч байна.

Баялаг Өлзий ХХК, Б.Балжинням: Бид бизнесийн загвараа өөрчлөөгүй ч зохион байгуулалтын өөрчлөлтүүдэд бол орсон. Манай үйлдвэрлэгчдэд hard skill нь байна. Харин soft skill буюу хандлага өөрчлөх тал дээр тусламж, хамтын ажиллагаа хэрэгтэй байна.

SFA, Б.Батхишиг: Менежментийн өөрчлөлтөнд яаралтай орох шаардлагатай болсон гэж үзэж байгаа. Засгийн Газрын зүгээс нөхцөл байдалтай холбоотойгоор хурдтай, уян хатан бодлого баримаар байна. Манай байгууллага дотоодын хэрэглэгчдийнхээ дунд тогтвортой ноолууран бүтээгдэхүүний худалдан авалтын талаар судалгаа явуулсан. Гэтэл 90% нь тогтвортой гэдгийг нь баталсан байвал худалдан авахад бэлэн гэж хариулсан.

WCS, Ж.Чанцаллхам: Бэлчээрийн чанар ноолуурын чанартай шууд хамааралтай. 2 хоршоо, 130 малчин өрхийг хамруулсан туршилтын ажил хийсэн. Үр дүн сайн байсан ч Ковид-той холбоотойгоор үнийн савлагаа үүсэхэд малчдын хоршоод бас сандарч эхэлсэн. Хэдийгээр онцгой нөхцөл байдал үүссэн ч гэсэн бэлчээр ашиглалтын чанарт тулгуурлан зах зээлийн үнээс 10% илүү үнэ өгч чадсан. Хэрэв баталгаажуулалт нь байгаад маркетинг сайн хийж чадвал Ковид-ийн нөхцөл байдалд ч гэсэн илүү үнээр зарах боломжтой нь харагдсан.

Үндэсний Хөгжлийн Газар, Хөгжлийн Бодлого Төлөвлөлтийн Газар, А.Мөнхболд: Хөгжлийн бодлого төлөвлөлт, удирдлагын тухай хууль батлагдсанаар их олон хууль дагаж өөрчлөгдсөн. Засгийн Газрын тухай хуулинд нэмэлт өөрчлөлт орсон байгаа. Аж үйлдвэрийг зөвхөн бодлогоор дэмжихгүй. Санхүүгээр, борлуулалтаар, нөөцийн удирдлагаар дэмжих ёстой. Эрх зүйн асуудлуудыг шинэчлэх хэрэгтэй байна. Төр, Хувийн хэвшил аль аль нь дундаасаа мөнгө гаргаад хамтран ажиллах, төр оролцох, уялдаа холбоог сайжруулах ийм загвар амжилттай явагдсан. Монгол улсын хувьд брэнд үүсгэх хамгийн ойрын боломж ноолуурын салбарт байгаа. Брэндээ үүсгээд, чанараа баталгаажуулаад гадны зах зээлүүдийг өдөөх хэрэгтэй байна. Мөн ноолуурын сан үүсгэх боломжтой. Холбоогоор дамжуулан үйлдвэрүүдтэй ганц цонхоор харилцаж байя. ЭШБайгууллагуудтай хамтран ажиллая. Нэгдсэн төлөлөгөөтөй больё.

Бодлого Судлалын Төв, А.Энх-амгалан: Ноолуурын салбарт үүсээд байгаа тогтворгүй байдлын шалтгаан нь ямааны үржил селекц муу, бэлчээр даацаа алдсанаас болж байна. Үйлдвэрлэгчид, малчид хоёр өрсөлдөгчид болчихоод байна. Нэг нь ямар нэг байдлаар үнэ унагах, нөгөө тал нь ямар нэг аргаар үнээ өсгөхийг оролдож байна. Малчдад Хас банкиар дамжуулан ногоон зээл олгосон. Хэрэв малын толгойг жилд 6% бууруулах юм бол хүүг 2 дахин буулгаж зээл өгөх, харин дахин өсгөсөн байвал буцаагаад нэмэх бодлого барихад 13% буурсан үр дүн гарсан. Хас банк үүнд тэрбум төгрөг зарцуулсан. EBRD-ас санхүүжилттэй бас нэг төсөл байна. Ноолуурыг чанарын баталгаатай болгосон. 2 сумаас 500, 500 тонныг бэлтгэсэн. Малчинд тоос шороогүй, ангилан ялгасан ноолуурт нь 1000 төгрөгний урамшуулал өгсөн. Ингэхэд үйлдвэрлэлийн гарц 48-52% болж өссөн. Нэг кг ноолуураас малчинд 3500 төгрөг ирэх боломжтой нь харагдсан. Иймэрхүү сайн загварууд байгаа ч дадал болгож, тогтолцоо бий болгоход энэ эх үүсвэрүүд огт хангалтгүй байна.

SFA, Б.Батхишиг: Манайд бас сайн туршлага байна. Мөшгих систем бий болгож туршсан. Баян-Овоо, Ханбогд сумдаас үнэлгээнд орж зохих бичиг баримтыг нь бүрдүүлсэн түүхий эдийг Johnston’s of Elgin худалдан авсан. 5 тонн ноолууранд манайх дардасаа өгөөд гааль дээр очсон байгаа. Ковид-ийн үед ч гэсэн ингэж ажиллаж болж байгаа. Түрүүн хувийн хэвшил, ЗГ-ийн

хооронд шинэ харилцаа үүсгэх загвар туршсан гэж А.Мөнхболд дарга хэлж байна. Ковид-ийг ашиглан ноолуурыг Хятадаас биш Монголоос татдаг болгох боломж гэж харж байна. Энэ ажил НҮБ-ийн энэ платформоор дамжин суурь нь бэлэн болж байна гэж гадаад зах зээл харж байгаа.

ХХААХҮЯам, В.Болормаа: Ноолуурын салбарт урт хугацааны таатай нөхцөл бүхий зээл эсвэл бага хүүтэй урт хугацааны зээл хэрэгтэй байна. Одоогийн байдлаар төрөөс олгож байгаа зээлийг цогц үйл ажиллагаатай 10 хэдэн үйлдвэр л аваад, ЖДҮ-үүд нь хаягдаад байна. Кластерийн журмаар ЖДҮ-ийг дэмжих бодлого барьж байна. Том жижиг аль аль нь Монгол ноолуурын нүүр царайг илэрхийлдэг байх ёстой.

Үндэсний Хөгжлийн Газар, Хөгжлийн Бодлого Төлөвлөлтийн Газар, А.**Мөнхболд:** Бид ноолуурын салбарыг дэмжих хөрөнгө оруулалтын сан гэж байгуулж болно. Гадны улсуудын хэрэгжүүлсэн амжилттай схем, моделиуд байж болно. Бид өөрсдөө салбарын мастер төлөвлөгөөтэй болох хэрэгтэй. Техник технологийн судалгаа, хүний нөөцийн судалгаа, ямааны үүлдрийн судалгааг нарийн гаргах хэрэгтэй. Энэ судалгаан дээрээ үндэслэн ноолуурын салбарыг дэмжих сан байгуулах бүрэн боломжтой.

Хэлэлцүүлэг 3. Ковид 19-той холбоотой үүссэн сорилтуудыг даван гарахын тулд Монгол Улсын Засгийн Газар болон ОУБ-ууд, хувийн хэвшил, бусад оролцогч талууд ямар арга хэмжээ авах хэрэгтэй гэж та бодож байна?

SFA, Б.Батхишиг: Малчдын хувьд хамтран ажилладаг хэдэн байгууллагуудынхаа хүрээнд л ажилладаг. ОУБ-дын үйл ажиллагааны талаар мэдээлэл сайн өгч хэрэгтэй байна. Бидний прогнозоор ирэх 18 сарын турш худалдан авалт зогсонги байдалтай, салбарын үйл ажиллагаа хуучин хэвэндээ орж чадахгүй. Бидэнд энэ байдал тодорхой байгаа учраас энэ сиймхийг ашиглаад зохион байгуулалтаа өөрчлөх, чадвар талаас нь хөгжүүлэх, сууриа үүсгэх, тогтвортой чиглэлийг нийтээр хүлээн зөвшөөрөх талаар хамтран ажиллах хэрэгтэй.

Үндэсний Хөгжлийн Газар, Хөгжлийн Бодлого Төлөвлөлтийн Газар, А.Мөнхболд: Ковид-той холбоотой нөхцөл байдалтай уялдуулан ярихад энэ хооронд мастер план байгаа бол шинэчлэе, тулгуур асуудлууд юу байгааг тодорхойльё. Системийн динамик загвар гаргая.

Бодлого Судлалын Төв, А.Энх-амгалан: Өмнө хэлсэнчлэн зээлийг бас шалгууртай болгомоор байна. ХАА салбарууд олон улсын банк санхүүгээс зээл авч чаддаггүй. Боловсруулах үйлдвэрээр дамжаад л авдаг. Чанарын үнэлэмж дээр тулгуурлах юм бол малчид хожих гээд байна. Гэтэл ЗГ олон улсын банк санхүүгийн эх үүсвэрээс зээл авчихаад ахиад л тоог өсгөх талыг дэмжээд байвал бидний ажил талаар болоод байна. Тийм учраас UNDP бас Монголдоо байгаа донорууд координац хийх үүрэгтэй байгаа учраас гадны хөрөнгө оруулагчдад ийм шалгуурууд бий шүү гэдгийг хэлвэл сайн байна.

UNDP-ийн Монгол дахь Суурин төлөөлөгчийн орлогч, С.Нашида:

Системийн хүрээнд хөшүүрэг ашиглан хувийн хэвшлийг яаж татан оролцуулах, салбар болгоны хувьд харилцан ашигтай байх загвар хэрхэн боловсруулахад системийн аргачлал их чухал ач холбогдолтой. Энд яригдаж байгаа бас нэг чухал асуудал нь нэмүү өртгийн сүлжээн дэхь бүх оролцогчдын хандлагын асуудал юм. Энэ бүгдийг авч үзэж, хэрэгжүүлэхийн тулд бүх оролцогчид жигд оролцоотой, шударга ашиг орлоготойгоор хамтран ажиллах нь чухал. Ийм тэнцвэртэй системийг бий болгохын төлөөх өнөөдрийн хэлэлцүүлэг үр дүнтэй болсон байх гэж бодож байна.

Үндэсний Хөгжлийн Газар, Хөгжлийн Бодлого Төлөвлөлтийн Газар, А.Мөнхболд:

Ирээдүйд аль болох цочролд бага орох системийн загвар гаргая. Олон сайн загвар бий. Энэ дээр ажиллая. Зураглал гаргая. Ноолуурын салбараа аваад нэг бодлоготой болж хөгжлийн 5 жилийн төлөвлөгөөнд тусгаад төсөв мөнгөө ч шийдээд явья. Экспортонд чиглэсэн эдийн засагтай болох гэдэг зорилтод хүрэхийн тулд ноолуурын хувьд pilot гаргах хэрэгтэй. Манайд хоршоодын тухай хуулийг өөрчлөх хэрэгтэй. Мэргэжлийн холбоод нь хоршоотойгоо сайн хамтарч ажиллах хэрэгтэй. Мөн кластерийн асуудал ч байна. Энэ дээр ОУБ-ууд хамтарч ажиллавал маш сайн.

UNDP-ийн Монгол дахь суурин төлөөлөгчийн орлогч, С.Нашида: UNDP-ийг төлөөлөн хэлэхэд системийн аргачлалыг хэрэгжүүлэх гэж байгаа бол бүрэн хэмжээгээр дэмжиж, хамтран ажиллах болно. Нөхцөл байдал маш хурдан өөрчлөгдөж байна. Системээр төлөвлөөд, нөхцөл байдлыг урьдчилан харж чаддаг тогтолцоог бий болгохын төлөө хамтран ажиллахад бэлэн байна.

МУЭИС, Ц.Будням: Кластерт суурилсан зураглал гаргах хэрэгтэй. Кластерийн бүтэц, зохион байгуулалтаа тодорхойльё.

МБАХ, Г.Намуулан: Яг Ковид-оос болоод ямар асуудлууд үүссэн, яаж шийдэх гэж байгаагаа тодорхойлоод хэвлэл мэдээллээр түгээх, хариуцсан бодлого боловсруулах түвшинд хүргэх нь зүйтэй байх

Бодлого Судлалын Төв, А.Энх-амгалан: ЗГ-ийн шинэ бүтэц, ХХААХҮ-ийн шинэ сайд г.м гол гол шийдвэр гаргах хүмүүст ажлаа сайн ойлгуулах, мөн бусад Донорууд дуу хоолойгоо хүргэх, ажилд нь оруулах шаардлагатай байна гэдэг санал байна.

WCS Ж.Чанцаллхам: Өнөөдрийн оролцогчид тус бүртээ зураглал гаргаад дараагийн уулзалт дээрээ хэлэлцэж тохироод түүнийгээ шинээр байгуулагдаж байгаа шийдвэр гаргах хүмүүст хүргэвэл яасан юм бэ. Системийн тогтолцооны хувьд, талууд өөр өөрсдийн зүгээс тогтвортой хөгжлийн тулгуур гурван үнэт зүйл дээрээ тулгуурлаад Монголын брэнд гаргахын төлөө бүгд ажиллавал ямар вэ?

SFA, Б.Батхишиг: Зураглалын хувьд бүх хүнтэй санал нийлж байна. Амжилттай болсон бүх туршлагууддаа дүн шинжилгээ хийгээд гүйцэтгэлд суурилсан үнэлгээ, урамшууллыг оруулж өгмөөр байна.

TNC, Л.Ням-очир: Малчны хариуцлага, бэлтгэн нийлүүлэлтийн системийг сайжруулах хэрэгтэй гэж бодож байна.

UNDP-ийн Монгол дахь суурин төлөөлөгчийн орлогч, С.Нашида: Монгол дахь UNDP-ийн зүгээс системийн тогтолцооны хэд хэдэн аргачлал дээр ажилласан байгаа. Одоогоор Монгол улсын хөгжлийн шинэ зураглал ашиглан бодлогын баримт бичиг гаргахаар ажиллаж байна. Мөн энэ загварыг Завхан, Орхон, Архангай, УБ хотуудтай хамтран хөрсний бохирдол, тогтвортой аялал жуулчлалын сэдвийн хүрээнд ашиглан хэрэгжүүлж эхний шатны үйл ажиллагаа дуусан байгаа. Энэ загварыг танай ажлын хэсэгт санал болгож байна.

Дүгнэлт, дараагийн алхмууд: Оролцогчид өөр өөрсдийн зүгээс замын зураглал гаргаж имэйл-ээр илгээх ба дараагийн уулзалтыг оролцогчдын санал дээр тулгуурлан товлоно. Уулзалт дээр замын зураглалыг эцэслэн шийдвэрлэнэ.